



Монгол улсын хил дээр

ЭРЛИЙН ҮЗҮҮР ХЯЗГААРГҮЙ...
/тэмдэглэл/

Өлгий сайхан орныхоо
Өлзийт алтан босгыг
Харж хамгаалах хилчин бид
Торгон хилээ манаж байна
Ирж халдах, хэнд ч адил
Хариу бэлэн хянаж байна...

Сулинхээрийн домогт хязгаарт, цэл залуухан насандаа энэ мөрүүдийг хэлхэж явсан өдрүүд тун саяхан санагдавч, мөн л хол хоцорч дээ.

Онгон залуугийн минь аагаар судас нь лугших миний шавь нарын цээжинд иймэрхүү биш юмаа гэхэд, тиймэрхүү мөрүүд огшиж, энэ сайхан хилдээ түр болоод буцах биш, бүр ирээд суурьших хүсэл цогшиж яваа болов уу.

Надад аз тохиож дадлага удирдах ажлаар баялаг түүхтэй бахархах үйлстэй, ажил сайтай, амжилт арвинтай, Улаан-Уулын хорооны хилийн суманд хэд хонох хувь тохиолоо.

Хилийн цэргийн тэргүүний хорооны захирагч хурандаа Х.Ранжинням, МХСҮН-ийг байгуулагдсан өдрөөс дэмжин, өөрөө үлгэрлэж бусдыгаа хошуучлан гишүүнээр элсэж, анги, салбарынхаа бүх офицер, ахлагч нараар тус нийгэмлэгээс эрхлэн гаргадаг "Хил судлал" сэтгүүлийг захиалуулан, тэртэй тэргүй шимтэн уншиж, шинийг эрэлхийлдэг залуусдаа хүртээл болгож байгаад нь баярлаад тус хорооны талаар товч тэмдэглэл тэрлэсэн минь энэ.

ЭХЛЭЛ. Түүхэн замналын шигтгээс

Тус отрядын түүх нь 1933 онд Дорноговь аймгийн нутагт тусгай комендатур байгуулагдсан үеэс эхэлдэг боловч ДЯА-ны сайдын 1936 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 05 тоот тушаалаар тусгай комендатурыг отряд болгон өргөтгөсөн үеэс тооцогддог.

Анхны даргаар Д.Ядамжавыг томилж, хилийн 12 дугаар отрядыг 3 суман, 1 байцаан өнгөрүүлэх, 6 заставтай зохион байгуулж, Дорноговь аймгийн хилийг бүрэн хариуцуулан өгчээ.

1936-1940 онуудад манай улсын хилийг зөрчсөн 1358 хүнийг хилчид баривчлан саатуулжээ.

1945 оны мичин жилийн зуднаар цасан шуурганд уруудаж ирсэн 70000 гаруй адууг орон нутгийн малчид, хөдөлмөрчдийн хамтаар 3 сарын хугацаанд тогтоон барьж түүхэнд "Их говийн зоригтнууд" гэж алдаршсан юм.

1945 оны чөлөөлөх дайнд Монгол-Зөвлөлтийн дайчдын давшилтыг хангах зорилгоор толгойн ба хажуугийн сэргийлэх отрядын үүргийг сайн гүйцэтгэсэн бөгөөд 1981 оноос 1998 оны 9 сар хүртэл 205 хил зөрчигч барьж, 1949 онд И.В.Сталины (1999.12.21-нд И.В.Сталины мэндэлсний 120 жилийн ой болсон ба "Вашингтон пост" түүнийг Зөвлөлт төрийн хамгийн том стратеги ч гэж нэрлэсэн. Д.Н) нэрэмжит болсон байна.

1967 оноос хойш командлалын шалгалтад 2 удаа "онц", гурван удаа "тэргүүн" дүнтэй шалгагдаж 1997 онд **ХИЛИЙН ЦЭРГИЙН ТЭРГҮҮНИЙ ОТРЯД** болсон юм.

1970 онд тус анги, байлдааны туг хүлээн авч, 1976 онд Засгийн газрын хүндэт жуух бичгээр шагнагдаж, 1973 онд "Үзүүр усны" заставыг Монгол Улсын баатар С.Лхагвадоржийн нэрэмжит болгон.

Түүх баяжуулсан алдартнууд

Дэд хурандаа С.Лхагвадорж. Монгол улсын баатар, 1948 оны 6 дугаар сард баруун хязгаарт их, бага Хавтаг, Мэргэн уулын орчимд Оспаны дээрэмчидтэй тулалдаж байгаад амиа алдсан.

Л.Гэндэн. Отрядын даргаар ажиллаж байсан. НАХЯ-ны 1 дүгээр орлогч сайд асан, МАХН-ын 3 удаагийн их хуралд сонгогдож, АИХ-ын депутатаар 6 удаа сонгогдсон.

Дэслэгч генерал Ш.Арвай. Отрядын даргаар ажиллаж байсан. НАХЯ-ны нэгдүгээр орлогч сайд Хилийн ба ДЦУЕТ-ын дарга, хожим нь БХЯ-ны орлогч сайд, Хилийн ба ДЦУЕТ-ын даргаар ажиллаж асан. Цэргийн шинжлэх ухааны доктор (PhD), профессор

Хошууч генерал Л.Баябазар. Отрядын даргаар ажиллаж байсан. МАХН-ын Их хурал, АИХ-д сонгогдож байсан.

Хурандаа Ц.Дамцагдорж, Отрядын даргаар ажиллаж байсан. АИХ-ын депутатаар сонгогдож, шинэ Үндсэн хууль

батлалцсан.

Хурандаа Х.Ранжинням. Хилийн цэргийн аварга отрядын дарга болсон.


Ахмад Х. Чулуунбаатар. Монгол улсын спортын мастер, марафон гүйлтийн улсын рекордыг 27 удаа эвдсэн.

Дэд хурандаа Г.Дурсгалжав. ХЦ-ийн аварга заставын даргаар 2 удаа шалгарсан.

Дэд хурандаа Д.Жамъяншарав. Хилийн цэргийн аварга заставын дарга болсон.

Энэ дотор миний шинэхэн танил Х. Чулуунбаатарын нэр байгаа нь тун сайхан санагдаж, хажуудаа байсан заставын дарга ахмад Наранбаатараас яадаг хүн бэ гэж асуухад, "гүйдэг хүн" гэж товч хариулсан юм.

"Гүйдэг хүн" буюу үлгэрлэдэг нэгэн



"Гүйдэг хүн" маань зүгээр нэг гүйдэг хүн биш, орон гүрэн дамжин гүйсэн, олон улсад нэр нь гарсан, зартай тамирчин, нэртэй мастер аж.

Бие нь ойрхон гүйдэгч, ухаан нь хол гүйдэг Х.Ранжинням хурандаа залуусынхаа эрэлд нэмэр хийж, дагаж дуурайх үлгэр болгож, халаагаа өгсөн ч жолоогүй тавиагүй, халамжтай буурлуудаа, хажуудаа бөөцийлсөөр явдгийн нэг нь гүйдэг хүн ажгуу.

Түүний тухай сэтгүүлч Ж.Эрдэнэпилийн бичиж, "Ээжийн бүүвэй" номондоо оруулсан "Өтөлж амжаагүй явна" найруулал түүх баяжуулсан алдартны нэгтэй та бүхнийг танилцуулах болно. Үнэг шиншлэх өглөөгүүр хүн гүйнэ. Өрх татах агшинд гүйж л харагдана.

Цэргийн ангийн хаяа дэрлэн буусан олон жилүүдэд үүр цүүрээр ганцаараа гүйдэг хүү үзээгүй, Эрдэнэ сумынхан ихэд сонирхдог байснаа төдөлгүй дасал болжээ. Цайгаа самраад цацал

өргөхөөр гарахад, цангасан морь ус руу хатирах шиг цаад хөтлөөс нөгөө хүний бараа айсуу үзэгдэнэ. Ийнхүү харагдах бараа хөдөөгийн амьдралд содон ч зарим нь “Цэргийн ангийн Чулуунбаатар л гүйж яваа биз” хэмээнүл ойшооно. Харин түүний гүйлтээс хожимдож босвол аавууд “Эртхэн босоход яадаг юм бэ, саахалтын хүн гүйж явахад манайх өрхөө татаагүй байх нь ичгэвтэр биш үү” гэж эхнэр хүүхдээ зэмлэх болсноор энэ нутгийнхан түүний гүйлттэй уралдан босно.

Сониучхандаа юмуу, эсвэл дагаж дуурайсандаа ч тэр үү, түүнийг бараадан дагаж гүйсэн хүн ч цөөнгүй. Ингэж олны анхаарлыг татаж бусдад үлгэрлэх болсон гүйдэг эр бол жар шүргэж яваа ч залуугийн жавхаагаа алдаагүй, гавьяаныхаа амралтад суусан ч холын зайн гүйлтээ орхиогүй Хорлоогийн Чулуунбаатар болой.

Тэр цэрэг амьдралын эрхээр энд тэнд шилжин ажиллаж байгаад насаа ахихад, Дорноговь аймгийн нутаг дахь хилийн отрядод биеийн тамирын зааварлагчийн алба хашиж, хожим тэндээ суурьшин амьдрах болжээ.

Тэрээр орон нутагтаа төдийгүй монгол улс даяар марафон гүйлтийн Чука гэж алдаршсан нэгэн бөлгөө.

1940 оны хаврын дунд сард Өвөрхангай аймгийн Тарагт суманд төрж, Онги, Оргийн голын зүлгэн дээр тугал сүүлдэж, хурга уургалж, үнээ ивэлгэж өссөн энэ хүн санхүүгийн техникумд орсон цагаасаа их, бага уралдаан тэмцээнд хүч сорьдог болов. Томоохон тэмцээний сураг сонсвол нойр хулжсан олон хоногуудыг тэсэж ядан өнгөрөөж, уралдсаны дараа сая санаа амардаг байж. Уралдаан бүхэн түүнд урам зориг, баяр баясгалан авчирна. Буурал цан бурзайсан идэр есийн хүйтэнд ч халуу төөнөсөн бүгчим зунаар ч тэр гүйж жаргал эдэлнэ. Гүйсний дараа бие хөнгөрөд алсын уулын хаяа ойрхон мэт, зөрөн өнгөрөх морьтны давхиаг гүйцэж түрүүлэх юм шиг санагддаг үе байсан.

Техникум төгсөж санхүүгийн мэргэжил эзэмшсэн ч өөрийн дуртай гүйлтийнхээ мөрийг хөөж амьдралаа төвхнүүлсэн хүн. Тэр 1966 оноос улсын шигшээ багт сургуулилахдаа хэд хэдэн зайд гүйлтийн дээд амжилт тогтоож, гал командад ажиллаж байхдаа гүйлтийнхээ хүчээр богино хугацаанд амжин очиж өдий төдий өмч хөрөнгийг галын аюулаас аварч, хилээс хилд томилогдон цэрэг дагаж явахдаа олон зуун хилчдийг гүйлтийн спортод дур сонирхолтой болгон бие бялдрыг нь хөгжүүлжээ. Тэр хаана ч явсан даргын өгсөн үүргийг мадаггүй гүйцэтгэгч, эгэл жирийн гүйгч билээ.

Залуу насандаа олон улсын, чанартай тэмцээнд улсаа

төлөөлөн 13 удаа оролцож, гүйхдээ цом авч, цолоо буудуулж байсан удаа ч бий. 1973 онд юмдаг. Ташкент хотноо явагдсан олон улсын гүйлтийн тэмцээнд 5 км-ийн зайд уралдахаар зэхэж байтал хэн нэгэн этгээд “Мах идсэн монгол гүйж чаддаггүй юм” гэж хэлэхийг сонсоод газар дайвтал гүйж түрүүлж байсандаа гэж өдгөө хуучилна.

Тэр бүх ард түмний гүйлтийн дээд амжилтыг 5 удаа шинэчилэн тогтоож улсын чанартай тэмцээнээс 23 алтан медаль авчээ. Тэрээр 1973 онд 42 км-ийн марафон гүйлтэнд 190 минут гүйж, улсын анхны дээд амжилт тогтоожээ. 1500 метрт 3,59 минут, 5 км-т 14,50 минут, 10 км-т 38 минут гүйж тогтоосон дээд амжилт нь одоо эвдэгдсэн ч гүйлтийн спортыг хөгжүүлэхэд түүний оруулсан хувь нэмрийг үгүйсгэх аргагүй.

Өвчилж эмнэлэгт хэвтэж, эм тариа хэрэглээгүй, өтөл насандаа дарагдаж овор суугаагүйн ачийг зөвхөн гүйлтийн буян гэж боддогтоо Чулуунбаатар гүйж насыг элээх нэгэн. Нас дээр гарлаа гэж гүйлтээ хаясангүй, тогтоосон дээд амжилтууд эвдэгдлээ гэж гутарсангүй, харин 1992 онд настайчуудын спартакиадад гүйгээд барианд орохдоо арынхаа хүнээс айл саахалтын хол зайд тасарч түрүүлж байлаа.

Улсын хилд 17 жил алба хашихдаа хилд явж манаа шалгах энэ тэрийн ажилд унаа хэрэглэсэнгүй, хол ойрын зайг хоёр зээрдээрээ туулсныг тооцвол дэлхийг тойрсонтой тэнцэх бизээ. “Чука ахмад ирсэн шүү, аягүй бол гүйгээд ирнэ, мэдээтэй байгаарай” гэж хилээ манасан цэрэг эмээж сонор сэрэмжээ дээшлүүлж байснаас үзэхэд түүний ач тус хил хамгаалалтад ч үр ашгаа өгсөн буюу.

Тэр 17 жил хилийн алба хашихдаа лавтай тооцоогоор 2 машин бензин хэмнэж, 70 морь бүтэн жилийн уналгаас чөлөөлж байна. Гүйлтийн эдийн засгийн тоон үзүүлэлтийн өнгөц харахад ийм авч бусдыг үлгэрлэн дуурайж, залуу үеийг гүйлтэд сургахад оруулсан ач тус нь үүнээс давуу билээ.

Үе тэнгийнхэн нь таяг тулчихсан, эсвэл өвчин хуучдаа баригдаж өвгөрсөн явахад Чулуунбаатар ид залуугийнхаа төрхөөр гялалзах нь чухамдаа гүйлтийн ачаар залуу насаа уртасгасан гэлтэй.

Гүйж жаргахын ач тус ийн буюу.

-Гүйх учиртай юм байлгүй дээ. Миний төрсөн газрын буйран дээр Арвайхээр хотын төв цэнгэлдэх хүрээлэн байгуулагдсан байна лээ. Хүн гүйдэг юм бол гүйнэ ч, түрүүлнэ ч гэж боддог гэж баясан өгүүлнэ. Спортын мастер болсноос хойш хорь гаран жил өнгөрсөн ч гүйлтээ хаясангүй. 1973 онд явагдсан Монголын Оюутан Залуучуудын анхдугаар наадамд 10 км-ийн гүйлтийн тэмцээнд

гутгаар байранд орсноос хойш дуулсан тэмцээн болгондоо аягасалгүй гүйсэн марафон гүйлтийн Чука сүүлийн жилүүдэд Эрдэнэ сумын нутгийн улаан толгодыг бугдийг тойрч гүйцээсэн байна.

Нарийн өвсийг найгуулан, наад цаад талын толгодын оройг торолзуулан гүйж явна. Ханиад хүрлээ ч гүйж эдгэрүүлнэ. Харшиж ядарлаа ч гүйж тэнхээжинэ.

Даарлаа гэж гүйх, халууцлаа гэж гүйх даанч овилгогүй юм шиг мөртлөө даруухан тэр гүйх болгондоо хөлсөө дуслуулж тайвширна. Тэр бүрийд бие нь тавирч залуугийн шидийг олно. Шалтаг мундахгүй гүйдэг, шандас цуцалгүй шогшдог Чулуунбаатар дасаж идээшиж буй Далайбумбатын заставтаа залуу хилчдээ үлгэрлээд, харуул суман хоёрынхоо хооронд хааяа хааяа гүйж л яваа.

Төгсгөл

“Цэрэг дайчид, офицер, ахлагч хэн хүнгүй, анги салбарынхаа ололт амжилтад баярлан бахархаж, алдаа дутагдалд гутран гонсойдог болсон тэр цагт тэнд зохиогдож байгаа зохион байгуулалт, хүмүүжлийн ажил хангагдлаа гэж үзэж болно” гэж нэрт жанжин М.В.Фрунзе сургасан байх юм. Х.Ранжинням дарга чухам ийм эрмэлзэл төрүүлэхээр алба ажлаа зохион байгуулж, хүн бүрийг дайчлан энэ эрэлд мордуулжээ.

Эдний залуус хийж бүтээхийн их хүслээр жигүүрлэн байнгын бодол, мөнхийн эрлээр ажиллаж амьдрах юм. Тэд яаж бусдаас ялгарч, олноос онцгойрч, түмнээс тасрах, яаж албыг бэхжүүлж, ажлыг сайжруулан, улсын хил халдашгүй дарханыг амаараа биш, ажлаараа харуулахаар уйгагүй эрэлхийлж, суулгүй ажиллаж байна. Ингэнэ тэгнэ гэсэн бэлэн жор байхгүйгээс хойш ажлыг сайжруулах аргыг, амжилтад хүргэх нууцыг ном, сэтгүүл уншиж хайна, юм юм сонсож хайна. Ахмадаасаа асууж хайна, анд нөхөдтэйгээ маргаж хайна, ажлынхантайгаа зөвлөж хайна.

Эцэс төгсгөлгүй эрэлд хатаж, энд тэндгүй хайна. Хайснаа олно, олсноо хэрэгжүүлнэ, болсноо бататгана.

Залуу нас ингэж эрвэлзэж,
эмээлт хүлэг дээр дарцаглан дэрвэлзэж,
цэргийнхээ дунд бужигнаж,
тэднийхээ дотор түчигнүүлж явдагсан
тийм л байна, тэргүүний хорооныхон. . .

*ХЦДС-ийн ахлах багш,
дэд хурандаа Д.Нямдорж*

